



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ,
ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ ДАРГА Ж.ЦОЛМОН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226-3168, Факс: (976-11) 31-23-15,
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2019.06.05 № 03/2989

танай _____-ны № _____-т

Сахилга хариуцлага, дэг журмыг
мөрдөж ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 02а дугаар албан даалгаврын хүрээнд тус яамны харьяа байгууллагын дарга, захирал дараах асуудлуудад анхаарч ажиллахыг үүрэг болгож байна.

1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, салбар харьяа байгууллагуудын тэмдэглэлт ойн арга хэмжээг тохиолдуулан нийтийн амралт, аялал, зугаалгыг зохион байгуулахыг хориглох, зөрчсөн тохиолдолд зохион байгуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох;

2. Томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх зэргийг хориглох, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;

3. Албан хаагчдын дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх;

4. Ээлжийн амралттай байгаа албан хаагчийн ажлыг орлох албан хаагчийг тухай бүр томилон ажил цалгардуулалгүй зохион байгуулах;

5. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шуурхай шийдвэрлэх;

6. Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай чирэгдэлгүй зохион байгуулах зэрэг болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

